МЭДЭЭ · 2023 оны 3-р сарын 28

# ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ӨМГӨӨЛӨГЧӨӨС ГАРГАСАН 322 ГОМДОЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭВ




Прокурорын байгууллага 2023 оны 3 дугаар сарын 20-ноос 24-ний өдрүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд болон өмгөөлөгчөөс гаргасан 398 гомдол, хүсэлтийг шинээр хүлээн авч, нийт 1049 гомдол, хүсэлтийг хянан шалгав. Үүнээс 322 гомдол, хүсэлтийг шийдвэрлэж холбогдох арга хэмжээг авсан бөгөөд одоо прокурорт 727 нь хянагдаж байна.

Шинээр хүлээн авсан гомдол, хүсэлтийн 10 нь ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой, 3 нь шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгуулах талаар байгаа бол 309 нь эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан гомдол, хүсэлт байна.

Дээрх хугацаанд Нийслэлийн Дүнжингарав, Мишээл төвүүдэд ажиллаж байгаа "Прокурорын байгууллагын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх төв"-үүд нийт 8 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч харьяа прокурорын газарт нь шилжүүлж, 17 иргэнд

прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг өгч ажиллав.

---

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1775